
АЖЛЫН БАЙРНЫ ЗАР · 2024 оны 11-р сарын 13

ПРОКУРОРЫН ТУСЛАХ АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР



Прокурорын туслах ажилтны ажлын байранд ажиллах хүсэлтэй иргэдийн сонгон шалгаруулалтыг "Прокурорын байгууллагын захиргааны албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх журам"-ын дагуу зохион байгуулна.

Нэг: Тавигдах болзол, шаардлага

- Монгол Улсын иргэн байх;

- Хууль зүйн дээд боловсролтой байх;

- Гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байгаагүй;

- Сэтгэцийн өвчин, эмгэггүй байх;

- Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх;

- Төрийн албаны тухай хуулийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөөгүй байх;

- Иргэний хувьд төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй байх;

- Энэ зард тавигдсан “Прокурорын байгууллагын захиргааны албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх журам” болон шаардлага, зөвлөмжтэй танилцсан байх.

Хоёр: Бүрдүүлэх материал

- Төрийн албан хаагчийн анкет

- Шалгалтад оролцохыг хүссэн өргөдөл

- Шалгалтад оролцох иргэний 3 үеийн намтар

- Бакалавр, түүнээс дээш боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичгийн баталгаажуулсан хуулбар / гадаадын их сургууль төгссөн бол баталгаат орчуулга/

- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн баталгаажуулсан хуулбар /төрийн албан хаагчид хамаарна/.

- Иргэний үнэмлэхний хуулбар

- Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг нотолсон баримт

- Цээж зураг 3 хувь / хэмжээ 4х6 см /

- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй бол баталгаажуулсан хуулбар

- Төрийн албаны ерөнхий шалгалтын дүнгийн хуудас

- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангарагийн хуудас” хуулбар

- Цэргийн албыг биечилж болон дүйцүүлэн хаасныг гэрчлэх баримт бичгийн баталгаажуулсан хуулбар

- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон байсан эсэх тухай тодорхойлолтыг /E-mongolia-аас татан авах/

Гурав: Албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангаж байгаа албан хаагч, иргэдэд шалгалт өгөх, өдөр, цаг, байршил болон бусад мэдээллийг **prosecutor.mn** сайтаар мэдээлнэ.

Дөрөв: Оролцогчид дээрх материалыг бүрдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн дотор Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг Бага тойруу Хуульчдын гудамж 15/1 хаягаар илгээх, эсхүл Улсын ерөнхий прокурорын газрын 103 тоот өрөөнд биечлэн хүлээлгэн өгөх боломжтой.

Бүртгэлийн хураамж 35.000 төгрөг

Холбоо барих утас: 88019466, 89990557